



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Амар тайван-Чингэлтэй 2028”
арга хэмжээ батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөө, төр, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэх зорилго бүхий “Амар тайван-Чингэлтэй 2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

“АМАР ТАЙВАН-ЧИНГЭЛТЭЙ 2028” АРГА ХЭМЖЭЭ

Нэг.Нийтлэг үндэслэл

Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад иргэд, олон нийтийн туслалцаа, дэмжлэгийг түшиглэх шаардлага бий болсон.

Энэхүү арга хэмжээ нь иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд тулгарч байгаа бэрхшээлийг төр, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран шийдвэрлэж, гэмт хэрэг, зөрчил, маргаантай асуудал үүсэж байгаа шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, бууруулахад чиглэсэн хамтын үйл ажиллагааг зохион байгуулах, шинэ хандлагыг төлөвшүүлэхэд энэхүү арга хэмжээ дэмжлэг үзүүлнэ.

Хоёр.Арга хэмжээний зорилго

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөө, төр, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэхэд энэ арга хэмжээний зорилго оршино.

1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийт, аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх;

2.Дүүргийн “Теле камерын хяналтын дэд төв”-ийн программ хангамжийг хөгжүүлж, түргэн тусламж, гал түймэр, гамшиг осол, цагдаагийн байгууллагын яаралтай дуудлагыг шуурхай хүлээн авч, гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон иргэдэд тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх;

3.Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, энэ орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах;

4.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч” нарын үйл ажиллагааг идэвхжүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулна;

5.Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон насанд хүрсэн болон насанд хүрээгүй иргэд, насанд хүрээгүй иргэдээс үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалгах, төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучлах, гэмт хэрэг, зөрчлөөс

урьдчилан сэргийлэх чиглэлийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай "Хүүхдэд ээлтэй" өрөөг бий болгож мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлэх;

6.Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх, эм, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн санд хяналт шалгалт хийх;

7.Утаат болон электрон тамхины хэрэглээ түүнээс насанд хүрээгүй хүүхэд, залуу үеийг хамгаалах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна;

8.Дүүргийн нутаг дэвсгэрт зам тээврийн осол, түүнээс урьдчилан сэргийлэх хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн олон талт арга хэмжээг зохион байгуулна;

9.Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх "Практик сургалтын талбай"-г байгуулан тогтмол ашиглах нөхцөл бололцоогоор хангах;

10.Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талд арга хэмжээ, хяналт, шалгалтыг зохион байгуулах;

11.Эрх бүхий албан тушаалтнуудыг авлига, ашиг сонирхолд өртөхөөс урьдчилан сэргийлж, зааварчилга, зөвлөмж өгч, баталгаа гаргуулан авч, сургалт зохион байгуулах;

Гурав.Арга хэмжээний зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Зорилт 1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийт, аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх.

2.1.Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр шинээр батлагдсан хууль, тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог дэмжих чиглэлээр олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

2.2.Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахин хамгаалах үйл ажиллагаанд олон нийт, иргэдийн сайн дурын оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулан, төрийн байгууллага, албан хаагчдын хүнд суртал, чирэгдлийг бууруулж, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлнэ.

2.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэгт (Оршин суугаа нутаг дэвсгэртээ нийтийн хэв журам сахиулах талаар нутгийн захиргааны байгууллага, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах байгууллагаас хэрэгжүүлж байгаа зохион байгуулалттай арга хэмжээг дэмжиж, сайн дураар оролцох) хуулийн хэрэгжилтийг хангуулж, хариуцсан нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдээс

иргэдийг нийтийн эргүүлд татан оролцуулан, үр дүнтэй ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж урамшуулна.

Хүрэх үр дүн: Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэдийн оролцоо, дэмжлэг сайжирч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэлтэй болж, иргэд хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх иргэдийн эрх зүйн мэдлэг, чадвар нэмэгдэнэ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй, нэгж, байгууллагаас эргүүлийн үүрэг гүйцэтгэх нийтийн эргүүлийг татан оролцуулснаар гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт нэмэгдэж, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг судлан тогтооход хамтын ажиллагаа, хариуцлага, үр дүн нэмэгдсэн байна.

Зорилт 2.Дүүргийн “Теле камерын хяналтын дэд төв”-ийн программ хангамжийг хөгжүүлж, түргэн тусламж, гал түймэр, гамшиг осол, цагдаагийн байгууллагын яаралтай дуудлагыг шуурхай хүлээн авч, гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон иргэдэд тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх.

2.1.Дүүргийн “Теле камерын хяналтын дэд төв”-ийн программ хангамжийг хөгжүүлж, түргэн тусламж, гал түймэр, гамшиг осол, цагдаагийн байгууллагын яаралтай дуудлагыг шуурхай хүлээн авч, нөхцөл байдлыг алсын зайнаас хянах тогтолцоог бий болгоно.

2.2.Гудамж талбай, олон нийтийн газруудад “SOS” кноп бүхий төхөөрөмж байрлуулж, Теле камерын хяналтын дэд төвд холбож, гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон иргэдэд тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.

Хүрэх үр дүн: Дүүргийн “Теле камерын хяналтын дэд төв”-ийн үйл ажиллагаа хэвийн явагдсанаар иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, амар тайван, эрүүл орчин бүрдэн бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон яаралтай тусламж шаардлагатай иргэдэд түргэн шуурхай тусламж үзүүлнэ.

Зорилт 3.Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, энэ орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах.

3.1.Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, мөрийтэй тоглоомд донтохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус, мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт, мэдээллийг зохион байгуулна.

3.2.Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран “ХУР” системд эрэн сурвалжлагдаж байгаа тээврийн хэрэгслийн арлын дугаарыг бүртгүүлэхэд системийн хөгжүүлэлтийн талаар хамтран ажиллана.

3.3.Гар утасны худалдаа эрхлэгч, болон түрээслэгч нарт үйл ажиллагаандаа ашиглах, худалдан авсан, худалдаалсан иргэний мэдээлэл, гар утасны сериал дугаарыг тогтмол бүртгэх “Бүртгэл”-ийн аппликэшн нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн: Төрийн болон төрийн бус, мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулснаар гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх талаар иргэдийн эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ.

Тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг багасна. Алдагдсан тээврийн хэрэгслийг түргэн шуурхай олно. Гэмт хэргийн замаар алдагдсан гар утас, ухаалаг төхөөрөмжийг хяналтад бүрэн авч, халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ, илрүүлэлт нэмэгдэж, гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурна.

Зорилт 4.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч” нарын үйл ажиллагааг идэвхжүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулна.

4.1.Ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч” нарын үйл ажиллагааг идэвхжүүлэн олон талт үйл ажиллагаа зохион байгуулна.

Хүрэх үр дүн:Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэг олгоход хүүхэд, хүүхдэд нөлөөлөх, хамгаалах замаар гэмт хэрэг, зөрчлөөс өөрийгөө хамгаалах мэдлэг, ойлголттой болж цаашид биеэ хэрхэн зөв авч явах, илүү хариуцлагатай болно.

Зорилт 5.Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон насанд хүрсэн болон насанд хүрээгүй иргэд, насанд хүрээгүй иргэдээс үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалгах, төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай “Хүүхдэд ээлтэй” өрөөг бий болгож мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлэх.

5.1.Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон насанд хүрсэн болон насанд хүрээгүй иргэд, насанд хүрээгүй иргэдээс үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалгах, төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай “Хүүхдэд ээлтэй” өрөөг бий болгосноор насанд хүрээгүй иргэдэд таатай уур амьсгал төрүүлж, тав тухтай байлгах, сэтгэл зүйч, хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хамт байж, хүүхэд айх аюулгүйгээр мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлнэ.

5.2.Байнга архидан согтуурч орчиндоо айдас түрүүлдэг удаа дараа хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж “Нэг бүрчилсэн хяналт”-д авагдсан иргэдийг нийгэмшүүлэх, сэтгэл заслын хариу арга хэмжээнд хамруулан ажил хөдөлмөрт зуучлах ажлыг зохион байгуулна.

Хүрэх үр дүн: Олон улсын стандарт шаардлага хангасан "Хүүхдэд ээлтэй" мэдүүлгийн өрөөтэй болсон байна. Архины хор хөнөөлийн талаар иргэдийн ойлголт сайжирч аливаа баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлыг архигүй тэмдэглэх хэвшлийг төлөвшүүлэх, архины хамааралтай иргэдийг сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулснаар архи хэтрүүлэн хэрэглэгчдийн тоо буурах, архинаас үүдэлтэй, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо багасах, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин тодорхой хувиар нэмэгдэнэ.

Ажилгүйдэл, ядуурал, гэр бүл салалт, архинаас үүдэлтэй гэмтэл, нас баралт, зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд буурна.

Зорилт 6.Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх, эм, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн санд хяналт шалгалт хийх, энэ төрлийн бодисын хор уршгийг олон нийтэд түгээх чиглэлийн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

6.1.Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх, эм, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан зэрэг газруудад хяналт шалгалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

6.2.Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд хүргэх чиглэлийн урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл бэлтгэж, түгээнэ.

Хүрэх үр дүн: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх хүүхэд, залуучууд, иргэдийн мэдлэг дээшлэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн гаралт буурсан байна.

Зорилт 7.Утаат болон электрон тамхины хэрэглээ түүнээс насанд хүрээгүй хүүхэд, залуу үеийг хамгаалах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах.

7.1.Утаат болон электрон тамхины хэрэглээ түүнээс насанд хүрээгүй хүүхэд, залуу үеийг хамгаалах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, насанд хүрээгүй иргэдэд утаат тамхи, электрон тамхи худалдан борлуулдаг зөрчлийг таслан зогсооно.

Хүрэх үр дүн: Утаат болон электрон тамхины хэрэглээ түүнээс насанд хүрээгүй хүүхэд, залуу үеийг хамгаалах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулснаар насанд хүрээгүй иргэдэд утаат тамхи, электрон тамхи худалдан борлуулдаг зөрчил таслан зогсоогдоно.

Зорилт 8.Дүүргийн нутаг дэвсгэрт зам тээврийн осол, түүнээс урьдчилан сэргийлэх хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн олон талт арга хэмжээг зохион байгуулна.

8.1.Дүүргийн нутаг дэвсгэрт хөдөлгөөний аюулгүй байдлын хангах шөнө оройн цагаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замд толь байрлуулах, тэмдэг, тэмдэглэлийг цацруулагчтай болгоно.

8.2.Хүүхдийг зам тээврийн осол, түүнээс урьдчилан сэргийлэх замын хөдөлгөөнд аюулгүй зөв боловсон оролцох мэдлэг олгох нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж энэ ажлын хүрээнд эцэг эх, асран хамгаалагч нарт Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг олгоно.

8.3.Тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор алслагдмал замуудад суурин хурд хэмжигч төхөөрөмжийг байршуулах ажлыг хар цэгийн судалгаанд үндэслэн гаргаж, Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй холбох ажлыг зохион байгуулна.

Хүрэх үр дүн: Иргэд, олон нийт Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг мэдсэнээр зам, тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол багасан Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилт хангагдана.

Зорилт 9.Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Практик сургалтын талбай”-г байгуулан тогтмол ашиглах нөхцөл бололцоогоор хангана.

9.1.Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд практикт суурилсан сургалтын талбайг байгуулж, сургалтын хөтөлбөрт оруулна.

Хүрэх үр дүн: Монгол Улсын иргэн сурч боловсрох эрхээр хангагдан, суралцах орчин сайжирч биет дадлага хийх боломж бүрдэж, эцэг, эх асран хамгаалагч, багш, сурагч нарт Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгож, хүний амь нас эрүүл мэнд, эд хөрөнгө, зам тээврийн осол хэргийн тоо үзүүлэлт буурна.

Зорилт 10.Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил арга хэмжээг зохион байгуулах.

10.1.Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагч нарын үйл ажиллагааг сайжруулах, иргэд олон нийтэд соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн аян зохион байгуулах

Хүрэх үр дүн: Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчил буурна.

Зорилт 11.Эрх бүхий албан тушаалтнуудыг авлига, ашиг сонирхолд өртөхөөс урьдчилан сэргийлж, зааварчилга, зөвлөмж өгч, баталгаа гаргуулан авч, сургалт зохион байгуулах.

11.1.Эрх бүхий албан тушаалтнуудыг авлига, ашиг сонирхолд өртөхөөс урьдчилан сэргийлж мэргэжлийн байгууллага, эрх бүхий албан тушаалтан энэ

чиглэлийн сургалтыг алба хаагч нарын дунд зохион байгуулуулах, зааварчилга, зөвлөмж өгөх, баталгаа гаргуулан авах.

Хүрэх үр дүн: Эрх бүхий албан тушаалтнууд авлига, ашиг сонирхолд өртөхөөс ангид байж, хуулиар хүлээлгэсэн үүргээ зохих ёсны дагуу хэрэгжүүлнэ.

Дөрөв.Хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

4.1.“Амар тайван-Чингэлтэй 2028” арга хэмжээ хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.1.1.Нэгдүгээр үе шат (2024-2026 он) Гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд таниулах, соён гэгээрүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг ажлыг зохион байгуулна.

4.1.2.Хоёрдугаар үе шат (2026-2028 он): “Амар тайван-Чингэлтэй 2028” арга хэмжээнд дунд хугацааны үнэлгээг хийж, шаардлагатай гэж үзвэл арга хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулна. Арга хэмжээн хэрэгжилтийн эцсийн үр дүнг тооцож, үнэлэлт, дүгнэлт өгнө.

4.2.Арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

4.2.1.Улс, нийслэл, орон нутгийн төсөв.

4.2.2.Олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хандивлагчдаас өгч буй тусламж, дэмжлэг, хуулиар зөвшөөрөгдсөн хандив.

4.2.3.Төр, олон нийт, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хандив, тусламж.

4.2.4. Бусад эх үүсвэр.

Тав.Хэрэгжүүлэгч байгууллага

- Дүүргийн Засаг даргын Тамгын газар
- Дүүргийн Цагдаагийн газар
- Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Чингэлтэй дүүргийн Замын цагдаагийн хэлтэс
- Дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс
- Дүүргийн боловсролын хэлтэс
- Дүүргийн 1-24 хороодын холбогдох төрийн болон төрийн бус байгууллага

Арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг Монгол Улсын Засгийн газрын бодлого хууль, эрх зүйн хүрээнд үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж ажиллах үүргийг хүлээнэ.

Зургаа.Хяналт, шинжилгээ, үнэлгээ, үр дүн шалгуур үзүүлэлт

Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь оролцогч талуудыг тэгш оролцоог хангаж, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ба үр дүнгийн хэрэгжилтийг жил бүр гаргаж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

Арга хэмжээний хэрэгжилтийг зорилтын биелэлт, үйл ажиллагааны чиглэлийн үр дүнгээр үнэлнэ.

Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг дараах аргачлалаар дүгнэнэ:

- “Үр дүнтэй”- зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь /90%-100%/
- “Тодорхой үр дүнд хүрсэн” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь /60%-89%/ хүртэл
- “Эрчимжүүлэх шаардлагатай”- зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь /31%-59%/
- “Үр дүн багатай” - зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 - /0%-30%/

Хяналт-шинжилгээ үнэлгээг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар хийнэ.

Шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин			
			2025 он	2026 он	2027 он	2028 он
Зорилт 1: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийт, аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.						
Шинээр батлагдсан хууль, тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах, оролцоог дэмжих олон талт арга хэмжээ зохион байгуулсан тоо	Тоо	90	91	92	93	95
Нийгмийн хэв журмыг сахин хамгаалах үйл ажиллагаанд олон нийт, иргэдийн сайн дурын оролцоог нэмэгдүүлсэн байдал хувиар	Хувь	82%	86%	88%	91%	94%

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдээс нийтийн эргүүлд татан оролцуулан үр дүнтэй ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж урамшуулсан хувиар	Хувь	80%	85%	90%	95%	99%
Зорилт 2: Дүүргийн "Теле камерын хяналтын дэд төв"-ийн программ хангамжийг хөгжүүлж, яаралтай түргэн тусламж, гал түймэр, гамшиг осол, цагдаагийн байгууллагын яаралтай дуудлагыг шуурхай хүлээн авч, нөхцөл байдлыг алсын зайнаас хянах тогтолцоог бий болгоно.						
Теле камерын хяналт, арчилгааны зардлыг шийдвэрлүүлж, ажиллахгүй байгаа камеруудыг ажиллагаанд оруулсан хувиар	Тоо	20%	50%	70%	80%	90%
Гудамж талбай, олон нийтийн газруудад "SOS" кноп бүхий төхөөрөмжийн байрлуулсан тоогоор	Тоо	1	20	35	55	100
Зорилт 3: Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, энэ орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулна.						
Сургалт арга хэмжээн зохион байгуулсан тоо	Тоо	15	20	40	60	80
"ХУР" системд эрэн сурвалжлагдаж байгаа тээврийн хэрэгслийн арлын дугаарыг бүртгүүлэх хөгжүүлэлтийн ажлын хувиар	Хувь	-	30%	50%	70%	90%
"Бүртгэл"-ийн аппликейшныг бий болгосон ажлын хувиар	Хувь	-	40%	70%	80%	90%
Зорилт 4: Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Өсвөрийн сэргийлэгч" нарын үйл ажиллагааг идэвхжүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулна.						
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Өсвөрийн сэргийлэгч" нарын үйл ажиллагаа зохион байгуулсан тоогоор	Тоо	2	5	8	12	20
Зорилт 5: Нийгэмд түгээмэл буй Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон насанд хүрсэн болон насанд хүрээгүй иргэд, насанд хүрээгүй иргэдээс үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалгах, төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай "Хүүхдэд ээлтэй" өрөөг бий болгож мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлнэ.						
"Нэг бүрчилсэн хяналт"-д авагдсан иргэдийг нийгэмшүүлэх, сэтгэл заслын хариу арга хэмжээнд хамруулах, ажил хөдөлмөрт зуучилсан хувиар	Хувь	5%	10%	15%	30%	50%

Олон улсын стандарт шаардлага хангасан хүүхдийн өрөөтэй болсон тоо	Тоо	1	2	3	4	5
Байнга архидан согтуурч, орчиндоо айдас түрүүлдэг иргэдийн тоо буурсан хувиар	Хувь	25%	40%	60%	80%	90%
Зорилт 6: Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх, эм, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн санд хяналт шалгалт хийх, энэ төрлийн бодисын хор уршгийг олон нийтэд түгээх чиглэлийн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.						
Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх, эм, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан зэрэг газруудад хяналт шалгалтыг үе шаттайгаар зохион байгуулсан тоогоор	Тоо	5	10	15	20	25
Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд хүргэх чиглэлийн урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл бэлтгэж, түгээсэн тоогоор	Тоо	10	20	30	40	50
Зорилт 7: Утаат болон электрон тамхины хэрэглээ түүнээс насанд хүрээгүй хүүхэд, залуу үеийг хамгаалах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.						
Утаат болон электрон тамхины хэрэглээ түүнээс насанд хүрээгүй хүүхэд, залуу үеийг хамгаалах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, насанд хүрээгүй иргэдэд утаат тамхи, электрон тамхи худалдан борлуулдаг зөрчил таслан зогсоогдсон буюу буурсан хувиар	Хувь	67.7%	70%	80%	90%	95%
Зорилт 8: Дүүргийн нутаг дэвсгэрт зам тээврийн осол, түүнээс урьдчилан сэргийлэх хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн олон талт арга хэмжээг зохион байгуулна.						
Иргэд, олон нийт Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг мэдсэнээр зам, тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирлын хувь	Хувь	67.7%	66.5%	66%	65.5%	65%
Зам тээврийн осол хэргийн тоо буурч, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө хамгаалагдаж, Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийн хувь	Хувь	67.7%	66.5%	66%	65.5%	65%

Зорилт 9. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Практик сургалтын талбай”-г байгуулан тогтмол нөхцөл бололцоогоор хангана.

Монгол Улсын иргэн сурч боловсрох эрхээр хангагдан, суралцах орчин сайжирч биет дадлага хийх боломж бүрдэж, эцэг, эх асран хамгаалагч, багш, сурагч нарт Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгож, хүний амь нас эрүүл мэнд, эд хөрөнгө, зам тээврийн осол хэргийн тоо	Тоо	54.8	55.0	55.5	56	56.5
---	-----	------	------	------	----	------

Зорилт 10. Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагч нарын үйл ажиллагааг сайжруулах, иргэд олон нийтэд соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн аян зохион байгуулах

Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчил буурсан хувиар	Хувиар	10	20	40	60	80
---	--------	----	----	----	----	----

Зорилт 11. Эрх бүхий албан тушаалтнуудыг авлига, ашиг сонирхолд өртөхөөс урьдчилан сэргийлж, зааварчилга, зөвлөмж өгч, баталгаа гаргуулан авч, сургалт зохион байгуулах.

Эрх бүхий албан тушаалтнууд авлига, ашиг сонирхлын гэмт хэрэгт өртсөн гэмт хэрэг буурсан хувиар	Хувиар	60%	70%	80%	90%	100%
---	--------	-----	-----	-----	-----	------